



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 37,900,000.00 (гучин долоон сая есөн зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 29,477,778.84 (хорин есөн сая дөрвөн зуун далан долоон мянга долоон зуун далан найман төгрөг наян дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Анхболд, Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн захирагч, хурандаа Э.Майдар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

133000294

4-r huraldaan.docx

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДЭСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
 ХИЛИЙН ЦЭРГИЙН 0214 ДҮТЭЭР АНГИД БАЛАНСААС БАЛАНСАД
 ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСАЛТ



Д/д	Автомашинны марк, улсын болон арлын дугаар.	Үйлдвэрлэсэн (ашиглалтад) орсон огноо	Нийт гүйлт (км)	Балансын үнэ, (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Уаз 220695, арлын дугаар ХТТ220695L 1213078, улсын дугаар 4240 УАН	2020	144,613	37,900,000.00	29,477,777.84	8,422,222.16
НИЙТ ДҮН				37,900,000.00 (Гучин долоон сая есөн зүүн мянга)	29,477,778.84 (Хорин есөн сая дөрвөн зүүн далан долоон мянга долоон зүүн далан найман төгрөг наян дөрвөн мөнгө)	8,422,222.16 (Найман сая дөрвөн зүүн хорин хоёр мянга хоёр зүүн хорин хоёр төгрөг арван зургаан мөнгө)